

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА Н.ЧИНБАТ ТАНАА

2021-03-09

Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолыг  
эс зөвшөөрч санал гаргах тухай

Нэр бүхий иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гучдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 хэсгийг зөрчсөн талаар мэдээлэл ирүүлснийг хүлээн авсан гишүүн үндэслэлтэй гэж үзэж, Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай 12, Маргаан нэгтгэн шалгах тухай 13, Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай 16 дугаар тогтоолуудыг тус тус гаргасан байна.

**Нэг.** Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц ... дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:” гээд 1 дэх заалтад “хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” гэж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль, бусад шийдвэрт аливаа зохицуулалтыг тусгаагүй гэх үндэслэлээр маргаан үүсгэн хянан шийдвэрлэх эрхгүй юм. Ийм эрх хэмжээг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар олгоогүй.

1.Дээрх иргэдийн мэдээллээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн нь Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрхэд халдсан гэж ойлгогдохоор байна. Үндсэн хуулийн “манаач” өөрөө Үндсэн хуульд халдагч байж хэрхэвч таарахгүй.

Үндсэн хуулийн цэцэд бүрэн эрхээ хэтрүүлэхгүй байх, чиг үүргээсээ халихгүй аливаа асуудалд хутгалдахгүй байх гэсэн өөрийн хил хязгаар байх ёстой.

Аливаа харилцааг яаж зохицуулах, хуульд хэрхэн тусгах нь хууль тогтоогчийн шийдэх (бүрэн эрхийн) асуудал.

Хэн нэгэн этгээд түүний дотор Үндсэн хуулийн цэц аливаа зохицуулалт, түүний хувилбарыг хууль тогтоогчид тулгах эрхгүй. Хэрэв Цэц тодорхой зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргавал өөрийн чиг үүргээс хальж улс төрийн бодлого боловсруулах ажиллагаанд оролцож хууль санаачлагч, улмаар

хууль тогтоогч болж хувирна. Төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчимд ч харшилахад хүрнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Хууль ... Үндсэн хуульд нийцээгүй гэх Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн ... шийдвэр гаргавал зохих хууль ... бүхлээрээ буюу тэдгээрийн зөрчилтэй зүйл, хэсэг, заалт **хүчингүй** болно.” гэж заасан.

Тэгвэл мэдээлэл гаргагчдын мэдээлэлдээ заасан хуулийн чухам аль заалтыг түдгэлзүүлж хүчингүй болгох нь тодорхойгүй хийсвэр болж байна. Иймээс дээрх мэдээллээр нэр бүхий иргэд Цэцэд маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх боломжгүй шаардлага тавьсан гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн ... заалтыг **зөрчсөн** тухай дүгнэлт гаргах ... бүрэн эрх бүхий байгууллага ... мөн.” гэж заасан. Аливаа өргөдөл, мэдээллийг хүлээн авсан Цэцийн гишүүн Үндсэн хууль зөрчөөгүй нь илэрхий байна гэж үзвэл маргаан үүсгэхгүй байх боломжтой.

2. Улсын Их Хурал бол хамтын удирдлагын, улс төрийн шинжтэй байгууллага бөгөөд шийдвэрээ олонхийн саналаар гаргадаг. Өөрийн батлан гаргасан хуулинд алдаа хийдэл байна гэж үзвэл хууль санаачлагчийн хувьд УИХ-ын гишүүн өөрөө хууль санаачилж өргөн барьж шийдвэрлүүлэх боломж бий.

Гэтэл олонхиор баталсан хуулиа УИХ-ын гишүүн өөрөө шууд Үндсэн хуулийн цэцэд хянуулахаар өгч байгаа нь Цэцийг хууль тогтоогч болгож хувиргах алхам руу түлхэж байна.

3. “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр олон тохиолдолд улс төрийн намжмал тогтвортой байдлыг бий болгодог” гэж ҮХЦ-ийн гишүүн асан Н.Жанцан дурдсан байдаг.

Гэтэл УИХ-ын гишүүн, ХҮН-ын дарга Т.Доржханд, тус намын нарийн бичгийн дарга Д.Үүрцайх нар мэдээлэл гаргасан нь Үндсэн хуулийн цэцэд өргөдөл мэдээлэл өгөх замаар улс төрийн тэмцлээ үргэлжлүүлж улмаар өөрсдийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр Цэцээр гаргуулах улс төрийн зорилготой гэж харагдаж байна.

Ийм санаархлыг Үндсэн хуульд ёсны үүднээс хамгаалж, таслан зогсоох нь Үндсэн хуулийн цэцийн үүрэг байх ёстой.

“Үндсэн хуулийн шүүх \Цэц\ улс төрийн шинжтэй асуудлаар төвийг сахих зарчмыг баримтлах нь ардчилсан Үндсэн хуультай орнуудад жишиг болон тогтохоос өөр аргагүй” гэсэн хуульч Д.Лүндээжанцангийн үг бий.

**Хоёр.** Монгол Улсын иргэн Ч.Доржгочоо, О.Дашням нарын иргэдээс 1997 оны 4 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан: “... П.Очирбат нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 1990-1993 онуудад сонгогдож ... бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгч болох нь тодорхой байхад ... Сонгуулийн Ерөнхий хороо 1997 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 03 тоот тогтоол гаргаж, Пунсалмаагийн Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэсэн нь ...”, “...

Одоогийн Ерөнхийлөгч П.Очирбатын нэрийг дахин нэр дэвшүүлсэн нь ...”, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэсэн агуулга бүхий мэдээлэл гаргасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1997 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж 03 дугаар дүгнэлтийг гаргажээ.

Цэц энэхүү дүгнэлтийг гаргахдаа **Үндсэн хуулинд заасан иргэний сонгох, сонгогдох үндсэн эрхийг дордуулахгүйн үүднээс** П.Очирбатыг гурав дахь удаагаа Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллах боломж олгож, нэр дэвшигчээр бүртгэн авсан Сонгуулийн Ерөнхий Хорооны 1997 оны 03 дугаар сарын 27-ны 03 тоот тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна гэж үзсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалтад “... уг маргааны талаар Цэцийн урьд гарсан дүгнэлт, тогтоол хүчинтэй байгаа.” бол Цэцийн гишүүн иргэнээс гаргасан өргөдөл мэдээллийг урьдчилан шалгаж, хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж тогтоол гаргахаар зохицуулсан байтал маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг ... Цэцийн аль нэг гишүүн эс зөвшөөрч ... санал бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.” гэж заасан.

Иймд нэр бүхий иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гучдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн талаар гаргасан мэдээллийг үндэслэлтэй гэж үзэж Үндсэн хуулийн цэцийн гишүүний гаргасан Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай 12 дугаар тогтоол, Маргаан нэгтгэн шалгах тухай 13 дугаар тогтоол, Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай 16 дугаар тогтоолыг тус тус эс зөвшөөрч санал гаргаж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаанаар хянан шийдвэрлүүлэхийг хүсье.

Дашрамд “Маргаан үүсгэсэн эсхүл маргаан үүсгэхээс татгалзсан тухай Цэцийн гишүүний тогтоолыг эс зөвшөөрч Цэцийн аль нэг гишүүн саналаа бичгээр гаргаж улмаар уг тогтоолыг Бага суудлын хуралдаанаар хянах боломжийг хуулиар олгосон нь нэг талаас маргагч болон маргалдагч талуудын эрхийг хамгаалах